

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, САНГИЙН САЙД, ХҮН АМЫН ХӨГЖИЛ,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2013 оны 12 дугаар
сарын 09 -ны өдөр

Дугаар 459 /200/182

Улаанбаатар хот

Даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний хувьсах зардлын
даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай


Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 12 дугаар
зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн болон хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний оношийн хамааралтай бүлгээр санхүүжүүлэх хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг хавсралтаар баталсугай.
2. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад олгох зардлын хэмжээг сонгон шалгаруулалтанд тэнцсэн, төрийн зарим үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэж буй хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллагуудын гэрээгээр гүйцэтгэж буй тусламж үйлчилгээнд нэгэн адил мөрдсүгэй.
3. Даатгуулагчид эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагуудтай хийх даатгалын гэрээнд энэхүү тушаалыг баримтлан ажиллахыг Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т зөвшөөрсүгэй.
4. Энэ тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгуулан ажиллахыг Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Я.Буянжаргал), Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар (Ж.Ганбат), Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс (Х.Мөнхзул), Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т тус тус даалгасугай.
5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (С.Төгсдэлгэр), Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар (Б.Батцэцэг), Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар (Э.Одбаяр)-т тус тус үүрэг болгосугай.

6. Энэ тушаалыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдсүгэй.

7. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2011 оны 12 дугаар сарын 30-ны 438/273/146 дугаар хамтарсан тушаал, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 160/95/57 дугаар хамтарсан тушаал, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 143/87/48 дугаар хамтарсан тушаалуудыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болсонд тооцсугай.





Эрүүл мэндийн, Сангийн, Хүн амын хөгжил
нийгмийн хамгааллын сайдын 2013 оны
12 дугаар сарын 29-ны өдрийн 459/200/182 дугаар
хамтарсан тушаалын хавсралт

Даатгуулагчид үзүүлэх тусламж үйлчилгээний хувьсах зардлын
даатгалын сангаас олгох хэмжээ

№	Тусламж үйлчилгээний төрөл	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллага	Хувийн өмчийн эрүүл мэндийн байгууллага
1	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээ	300 000	175 000
2	Өдрөөр эмчлэх тусламж, үйлчилгээ	135 000	0
3	Амбулаторийн тусламж үйлчилгээ	15 000	0
4	Оношлогоо шинжилгээ	55 000	0
5	Уламжлалт эмчилгээ	117 000	117 000
6	Сэргээн засах тусламж, үйлчилгээ	110 000	110 000
7	Хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ	300 000	175 000
8	Дараалсан 3 жилийн хугацаанд тусламж үйлчилгээний зардал гаргаагүй даатгуулагчийг нэг удаа эрүүл мэндийн бүрэн үзлэгт хамруулах үйлчилгээ	80 000	80 000